ЗАВХАН АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ЗАА-2022/207/СТА-ТШЗ**


Дарга, Тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 70463612 Цахим хаяг: batundraa@audit.gov.mn

Ахлах аудитор : Б.Дагвасүрэн

Утас:99014227 Цахим хаяг:dagvasurenb@audit.gov.mn

Аудитор П.Ганцолмон

Утас:70157405 Цахим хаяг:uliastaivanaudit@ubaudit.mn


Цахим хуудас: www.audit.mn

Улиастай хот

2022 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1. **Аудитын санал дүгнэлт** .......... 2
2. **Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**
   2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .......... 4
   2.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан .......... 5
   2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .......... 7
   2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .......... 8
   2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .......... 10
3. **Аудитын тайлан**
   3.1 Ерөнхий зүйл .......... 12
   3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .......... 12
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .......... 12
   3.4 Материаллаг байдал .......... 13
   3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .......... 13
   3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .......... 14
   3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .......... 14
   3.8 Аудитын гол асуудал .......... 14
   3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал, Шилэн дансны хуулийн хэрэгжилт, бусад хууль тогтоомж .......... 14
   3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .......... 15
   3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .......... 15
4. **Аудитын илрүүлэлт** .......... 15

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1. Төрийн аудитын санал, дүгнэлт

ХӨДӨЛМӨР ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА Б.РИНЧИНДОРЖ-Д

**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12

2022.02.24 № 1302/180

танай ______ -ны № ______ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **5,613,300.00** | **8,709,100.00** |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | 5,613,300.00 | 8,709,100.00 |
| 354 | **Хангамжийн материал** | 5,613,300.00 | 8,709,100.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 5,613,300.00 | 5,976,300.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | - | 2,732,800.00 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,189,547,162.36** | **1,175,177,053.31** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,189,547,162.36 | 1,175,177,053.31 |
| 391 | Газар | 49,510,000.00 | 49,510,000.00 |
| 392 | **Биет хөрөнгө** | 1,133,097,162.36 | 1,118,727,053.31 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,925,529,645.00 | 1,925,529,645.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (995,354,411.06) | (1,008,856,831.06) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 78,700,000.00 | 117,649,761.95 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (78,700,000.00) | (78,700,000.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 453,853,757.07 | 462,114,557.07 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (301,097,977.07) | (322,604,405.07) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 221,096,190.92 | 221,096,190.92 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (184,448,942.50) | (211,020,765.50) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 13,518,900.00 | 13,518,900.00 |
| 393 | **Биет бус хөрөнгө** | 6,940,000.00 | 6,940,000.00 |
| 39301 | Програм хангамж | 6,940,000.00 | 6,940,000.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,195,160,462.36** | **1,183,886,153.31** |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,195,160,462.36** | **1,183,886,153.31** |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,195,160,462.36 | 1,183,886,153.31 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 222,854,476.00 | 222,854,476.00 |
| 512 | **Хуримтлагдсан үр дүн** | 941,413,450.36 | 930,139,141.31 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 907,105,628.34 | 941,413,450.36 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 34,307,822.02 | (11,274,309.05) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 30,892,536.00 | 30,892,536.00 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,195,160,462.36** | **1,183,886,153.31** |

## 2.2 Аудит хийсэн Санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,152,921,705.43** | **884,549,300.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **289,251,005.43** | **27,623,800.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 289,251,005.43 | 27,623,800.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 289,251,005.43 | 27,623,800.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 54,593,000.00 | |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 234,658,005.43 | 27,623,800.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **863,670,700.00** | **856,925,500.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 848,092,700.00 | 842,246,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 848,092,700.00 | 842,246,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 15,578,000.00 | 14,679,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 15,578,000.00 | 14,679,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,118,613,883.41** | **895,823,609.05** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,118,613,883.41** | **895,823,609.05** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,099,974,851.41 | 891,981,079.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 641,461,844.00 | 641,478,835.00 |
| 210101 | Үндсэн цалин | 459,308,579.00 | 471,944,065.00 |
| 210102 | Нэмэгдэл | 148,927,783.00 | 150,555,748.40 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 33,225,482.00 | 18,979,021.60 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 86,604,372.00 | 84,247,709.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 86,604,372.00 | 59,175,784.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | - | 6,590,596.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | - | 5,181,757.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | - | 1,209,052.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | - | 12,090,520.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 95,536,557.00 | 78,853,592.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,330,639.00 | 4,122,115.00 |
| 210302 | Түлш, халаалт | 87,858,520.00 | 69,159,520.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,347,398.00 | 5,571,957.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 17,949,191.00 | 11,812,486.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,438,690.00 | 1,425,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,067,383.00 | 7,495,675.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,087,018.00 | 1,367,111.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 350,600.00 | 280,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,005,500.00 | 1,243,900.00 |
| **2105** | **Норматив зардал** | 18,646,899.00 | - |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 800,000.00 | - |
| 210502 | Хоол, хүнс | 16,346,899.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,500,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,738,200.00 | 594,600.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,738,200.00 | 594,600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,440,600.00 | 3,592,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,440,600.00 | 3,592,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 31,671,605.00 | 9,820,686.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 29,522,921.00 | 6,321,300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,096,000.00 | 1,180,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 255,700.00 | 499,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 80,600.00 | 135,386.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 470,000.00 | 1,385,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 246,384.00 | 300,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 203,925,583.41 | 61,580,671.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,575,400.00 | - |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 200,350,183.41 | - |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | | 61,580,671.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 18,639,032.00 | 3,842,530.05 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 15,154,400.00 | 850,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 14,054,400.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,100,000.00 | 850,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 2,992,530.05 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 2,992,530.05 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 3,484,632.00 | - |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,484,632.00 | |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **34,307,822.02** | **(11,274,309.05)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **34,307,822.02** | **(11,274,309.05)** |

## 2.3 Аудит хийсэн Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 222,854,476.00 | 30,892,536.00 | 907,105,628.34 | - | **1,160,852,640.34** |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **222,854,476.00** | **30,892,536.00** | **907,105,628.34** | - | **1,160,852,640.34** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 34,307,822.02 | - | **34,307,822.02** |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **222,854,476.00** | **30,892,536.00** | **941,413,450.36** | - | **1,195,160,462.36** |
| D01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **222,854,476.00** | **30,892,536.00** | **941,413,450.36** | - | **1,195,160,462.36** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **222,854,476.00** | **30,892,536.00** | **941,413,450.36** | - | **1,195,160,462.36** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (11,274,309.05) | - | **(11,274,309.05)** |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **222,854,476.00** | **30,892,536.00** | **930,139,141.31** | - | **1,183,886,153.31** |

## 2.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **918,263,700.00** | **856,925,500.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **54,593,000.00** | - |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 54,593,000.00 | - |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 54,593,000.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 54,593,000.00 | |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **863,670,700.00** | **856,925,500.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 848,092,700.00 | 842,246,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 848,092,700.00 | 842,246,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 15,578,000.00 | 14,679,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 15,578,000.00 | 14,679,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **918,263,700.00** | **856,925,500.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **918,263,700.00** | **856,925,500.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **899,624,668.00** | **853,082,969.95** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 641,461,844.00 | 641,478,835.00 |
| 210101 | Үндсэн цалин | 459,308,579.00 | 471,944,065.00 |
| 210102 | Нэмэгдэл | 148,927,783.00 | 150,555,748.40 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 33,225,482.00 | 18,979,021.60 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 86,604,372.00 | 84,247,709.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 86,604,372.00 | 59,175,784.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | - | 6,590,596.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | - | 5,181,757.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | - | 1,209,052.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | - | 12,090,520.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 95,536,557.00 | 78,853,592.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,330,639.00 | 4,122,115.00 |
| 210302 | Түлш, халаалт | 87,858,520.00 | 69,159,520.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,347,398.00 | 5,571,957.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 17,949,191.00 | 14,545,286.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,438,690.00 | 1,425,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,067,383.00 | 10,228,475.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,087,018.00 | 1,367,111.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 350,600.00 | 280,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,005,500.00 | 1,243,900.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 18,646,899.00 | - |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 800,000.00 | |
| 210502 | Хоол, хүнс | 16,346,899.00 | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,500,000.00 | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,738,200.00 | 594,600.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,738,200.00 | 594,600.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,440,600.00 | 3,592,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,440,600.00 | 3,592,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 31,671,605.00 | 29,770,447.95 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 29,522,921.00 | 26,271,061.95 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,096,000.00 | 1,180,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 255,700.00 | 499,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 80,600.00 | 135,386.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 470,000.00 | 1,385,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 246,384.00 | 300,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3,575,400.00 | - |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,575,400.00 | |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **18,639,032.00** | **3,842,530.05** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | - | - |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 15,154,400.00 | 850,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 14,054,400.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,100,000.00 | 850,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 2,992,530.05 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 2,992,530.05 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 3,484,632.00 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,484,632.00 | |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.5 Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **893,247,500.00** | **842,246,500.00** | **51,001,000.00** | **94%** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **893,247,500.00** | **842,246,500.00** | **51,001,000.00** | **94%** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **892,312,700.00** | **841,396,500.00** | **50,916,200.00** | **94%** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **641,514,500.00** | **641,478,835.00** | **35,665.00** | **100%** |
| 210101 | Үндсэн цалин | 484,413,500.00 | 471,944,065.00 | 12,469,435.00 | 97% |
| 210102 | Нэмэгдэл | 136,410,000.00 | 150,555,748.40 | (14,145,748.40) | 110% |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 20,691,000.00 | 18,979,021.60 | 1,711,978.40 | 92% |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **86,604,400.00** | **84,247,709.00** | **2,356,691.00** | **97%** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 60,943,900.00 | 59,175,784.00 | 1,768,116.00 | 97% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,415,100.00 | 6,590,596.00 | (175,496.00) | 103% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,132,100.00 | 5,181,757.00 | (49,657.00) | 101% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,283,000.00 | 1,209,052.00 | 73,948.00 | 94% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,830,300.00 | 12,090,520.00 | 739,780.00 | 94% |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **79,032,200.00** | **78,853,592.00** | **178,608.00** | **100%** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 13,984,700.00 | 4,122,115.00 | 9,862,585.00 | 29% |
| 210302 | Түлш, халаалт | 58,075,400.00 | 69,159,520.00 | (11,084,120.00) | 119% |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,972,100.00 | 5,571,957.00 | 1,400,143.00 | 80% |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **8,548,800.00** | **5,953,516.00** | **2,595,284.00** | **70%** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,426,500.00 | 1,425,300.00 | 1,200.00 | 100% |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,642,000.00 | 1,636,705.00 | 5,295.00 | 100% |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,448,700.00 | 1,367,111.00 | 81,589.00 | 94% |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 302,700.00 | 280,500.00 | 22,200.00 | 93% |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,728,900.00 | 1,243,900.00 | 2,485,000.00 | 33% |
| **2105** | **Нормативт зардал** | **17,355,000.00** | - | **17,355,000.00** | **0%** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,500,000.00 | - | 1,500,000.00 | 0% |
| 210502 | Хоол, хүнс | 14,355,000.00 | - | 14,355,000.00 | 0% |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,500,000.00 | - | 1,500,000.00 | 0% |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,592,200.00** | **594,600.00** | **1,997,600.00** | **23%** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 602,200.00 | 594,600.00 | 7,600.00 | 99% |
| 210604 | Урсгал засвар | 1,990,000.00 | - | 1,990,000.00 | 0% |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **56,665,600.00** | **27,370,447.95** | **29,295,152.05** | **48%** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 54,071,000.00 | 24,871,061.95 | 29,199,938.05 | 46% |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,180,000.00 | 1,180,000.00 | - | 100% |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 499,000.00 | 499,000.00 | - | 100% |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 158,400.00 | 135,386.00 | 23,014.00 | 85% |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,400.00 | - | 44,400.00 | 0% |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 396,000.00 | 385,000.00 | 11,000.00 | 97% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210807 | Газрын төлбөр | 316,800.00 | 300,000.00 | 16,800.00 | 95% |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **934,800.00** | **850,000.00** | **84,800.00** | **91%** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **934,800.00** | **850,000.00** | **84,800.00** | **91%** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 934,800.00 | 850,000.00 | 84,800.00 | 91% |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **-** | **2,897,800.05** | **(2,897,800.05)** | |
| 213503 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | | 2,897,800.05 | (2,897,800.05) | |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 893,247,500.00 | 842,246,500.00 | 51,001,000.00 | 94% |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **842,246,500.00** | **842,246,500.00** | **-** | **100%** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 842,246,500.00 | 842,246,500.00 | - | 100% |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **51,001,000.00** | **-** | **51,001,000.00** | **0%** |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 51,001,000.00 | | 51,001,000.00 | 0% |

## 2.6 Аудит хийсэн Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **14,679,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **14,679,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 14,679,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 8,591,770.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,591,770.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,592,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,592,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,400,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,400,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,000,000.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **94,730.00** |
| 213503 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 94,730.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 14,679,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 14,679,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 14,679,000.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллага  Хөдөлмөр халамж үйлчилгээний газар-тай  холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Улиастай ван аудит ХХК-ийн ахлах аудитор П.Ганцолмон, аудитор Д.Гэрэлхүү нар гүйцэтгэж, ахлах аудитор Б.Дагвасүрэн, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөдөлмөр халамж үйлчилгээний газар-т 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дугаар сарын 24-ны өдрийн 03/22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөдөлмөр халамж үйлчилгээний газар нь Төрийн хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ил тод нээлттэй, шударга байх зарчмыг баримталж иргэдэд үзүүлэх нийгмийн халамж, үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай хүргэх зорилготой  Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг аймгийн нутаг дэвсгэрт бүрэн дүүрэн хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэг бүхий ажлын алба юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хөдөлмөр халамж үйлчилгээний газар нь Дотоод аудитын нэгж байхгүй.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино. Өмнө Хөдөлмөр халамж үйлчилгээний газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил

гүйлгээг аккруэл суурьар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг дахин тогтоож АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл 8,800.0 мянган төгрөг гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 70 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлогын 884,549.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 8,845.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоосон материаллаг байдлын 70 хувиар буюу 6,200.0 мянган төгрөгөөр тогтоосон.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | - | - |
| Бараа | 5,613.3 | 8,709.1 | 3,095.8 |
| Үндсэн хөрөнгө | 1,189,547.2 | 1,175,177.0 | -14,370.2 |
| **Нийт хөрөнгө** | **1,195,160.5** | **1,183,886.1** | **-11,274.4** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,195,160.5 | 1,183,886.1 | -11,274.4 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө** | **1,195,160.5** | **1,183,886.1** | **-11,274.4** |

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 3,095.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь түлш тослох материалын үлдэгдэл нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 14,370.1 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардалтай холбоотой.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 893,247.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 842,246.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан урсгал зардалд зарцуулсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 842,246.5 мянган төгрөгийн санхүүжилт, урсгал үйл ажиллагаанд 839,348.7 мянган төгрөгийг зарцуулж, 2,897.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 14,679.0 мянган төгрөгийн санхүүжилтын орлогыг бараа хангамжийн зардалд 8,591.7 мянган төгрөг, томилолтын зардалд 3,592.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 2,400.0 мянган төгрөгийг зарцуулж, 94.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

**3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

**3.8 Аудитын гол асуудал**

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

**3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

**3.9.1 Шилэн ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 148 мэдээллээс 143 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй хугацаа болоогүй 5 мэдээлэл байна.

**3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжиийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

**3.10 Өмнөх ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар ”Зөрчилгүй” үнэлгээ авч зөвлөмж өгөгдөөгүй байна.

**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**
**Анхаарал татахуйц алдаа зөрчилгүй илрээгүй.**

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар и баримт бүрдүүлэлтээр 1,361.4 мянган төгрөгийн алдаа илэрүүлсэн ба түүнд зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар залруулсан алдаа байхгүй.

### 4.2 Төлбөрийн акт тогтоогоогүй

### 4.3 Албан шаардлага хүргүүлээгүй.

### 4.4 Зөвлөмж

✓ Илрүүлэлт: Тайлант хугацаанд 110,245.3 мянган төгрөгийн худалдан авалт хийснийг и баримтын цахим бүртгэлтэй тулгахад 1,361.4 мянган төгрөгийн гүйлгээ нь и баримтгүй байгаа нь нотлогдлоо.

✓ Өгсөн зөвлөмж: И баримтыг бүрдүүлээгүй зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"; Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ."; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**4.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл** /сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Хөдөлмөр халамж үйлчилгээний газар | 1 | 1.4 | - | - | - | - | - | - | 1 | 1.4 |